



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/143

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 26 дугаар зүйлийн 26.1.22 дахь хэсэг, Дээд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Оюутан элсүүлэх журам”-ыг нэгдүгээр, “Элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал”-ыг хоёрдугаар, “Дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөлтийн журам”-ыг гуравдугаар, “Дипломын загвар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Дээд боловсролын сургалтын байгууллагын ректор, захирлуудад үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллахыг Дээд боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /Х.Тамир/-т даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтийн хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллага, Боловсролын ерөнхий газар, Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллагын үйл ажиллагаанд жил бүрийн 11 дүгээр сард багтааж хяналт шалгалт хийж ажиллахыг Салбарын хяналтын газар /Л.Төгсбаяр/-т даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

14241 0448

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20 – ны өдрийн А/143 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургууль” гэх)-ын дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх үйл ажиллагаа, элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлалтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Оюутан элсүүлэх үйл ажиллагаа “Боловсролын ерөнхий хууль”, “Дээд боловсролын тухай” хууль болон бусад холбогдох эрх зүйн баримт бичигт нийцсэн байна.
- 1.3. Оюутан элсүүлэх үйл ажиллагаанд ил тод, шударга, мэдээлэл, зар сурталчилгаа үнэн зөв, ойлгомжтой, хүртээмжтэй байх зарчмыг баримтална.
- 1.4. Оюутан элсүүлэх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулж болно. Цахим элсэлтэд техник тоног төхөөрөмж, программ хангамж болон бусад шаардлагатай дэд бүтцийг бүрэн бүрдүүлсэн байна.
- 1.5. Элсэлтийн шалгалтын хичээл, ур чадварын шалгалт, үндэсний босго оноог мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/ тус бүрээр Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

Хоёр. Элсэгчдэд тавих шаардлага

- 2.1. Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой иргэнийг дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсүүлнэ.
- 2.2. Тухайн хөтөлбөрийн элсэлтийн шалгалтын хичээл, босго оноо, сургуулиас тавьсан бусад шалгуур, шаардлагыг хангасан байна.
- 2.3. Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаас цахимаар олгосон элсэлтийн шалгалтын дүнг илэрхийлсэн батламжтай байна.
- 2.4. Дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт суралцах хүсэлтэй иргэнийг дараах тохиолдолд элсэлтийн шалгалтын оноо шаардахгүйгээр элсүүлэн суралцуулж болно. Үүнд:
 - 2.4.1. Дэд бакалавр, бакалаврын боловсролтой иргэн;
 - 2.4.2. Дээд боловсролын тухай хуулийн 18.2 -д заасан сургуулийн төгсөгч;
 - 2.4.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 медальт байрт шалгарсан иргэн тухайн чиглэлийн хөтөлбөрт;
 - 2.4.4. Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн;

2.4.5.Гадаадын аль нэг улсын дээд боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагын ижил түвшний хөтөлбөрт шилжин суралцах иргэн;

2.4.6.Элсэн суралцах мэргэжлийн чиглэл/хөтөлбөр/-ээр 3-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн;

2.4.7.Шашны боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад элсэгч.

2.5.Элсэгч сургуулийн элсэлтийн журамтай танилцаж, элсэлтийн системд бүртгүүлнэ.

2.6.Олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургууль төгсөгч олон улсын шалгалтын үнэлгээгээ элсэлтийн шалгалтын үнэлгээнд дүйцүүлэх эсвэл элсэлтийн шалгалтад хамрагдаж авсан ононыхоо аль өндөр оноогоороо сургуульд элсэн орж болно.

Гурав.Элсэлтийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх үүрэг

3.1.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагын эрх, үүрэг:

3.1.1.Элсэлтийн шалгалтыг батлагдсан журмын дагуу жилд хоёр удаа үндэсний хэмжээнд зохион байгуулна.

3.1.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрсний дагуу элсэлтийн шалгалтын бүртгэл, хураамж, шалгалтын тов болон хуваарийг тогтооно.

3.1.3.Элсэлтийн шалгалтад ялгаатай хэрэгцээт шалгуулагч хамрагдахад шаардагдах шалгалт өгөх нэмэлт анги танхим, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах бөгөөд суралцагчийн шалгалт өгөх өдөр, шалгалтын үргэлжлэх хугацааг сунгах зэрэг асуудлыг хариуцан зохион байгуулна.

3.1.4.Гадаадын улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг Кембрижийн AS /advanced subsidiary/, A /advanced/, болон IB /international baccalaureate/ түвшний хөтөлбөр, IELTS /International English Language Testing System/, TOEFL /Test of English as a Foreign Language/, SAT /Scholastic Aptitude Test/-ын үнэлгээг Монгол Улсын элсэлтийн шалгалтын үнэлгээтэй дүйцүүлж батламж олгоно.

3.1.5.Элсэлтийн шалгалтын бүтэц, агуулгын өөрчлөлттэй холбоотойгоор элсэгчдэд зориулсан элсэлтийн шалгалтын жишиг материал, тестүүдийг Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагын цахим хуудсанд байршуулан, иргэдийг мэдээллээр хангаж ажиллана.

3.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын эрх, үүрэг:

3.2.1.Сургуулийн оюутан элсүүлэх журмыг энэ журамд нийцүүлэн сургуулийн гүйцэтгэх удирдлага батлах бөгөөд дараах шаардлагыг заавал тусгасан байна. Үүнд:

3.2.1.1.Бүртгүүлэгчид тавих нийтлэг болон тусгай шаардлага;

3.2.1.2.Оюутан элсүүлэх хөтөлбөр, тэдгээрт харгалзах элсэлтийн шалгалтын сургуулийн тогтоосон босго оноо;

3.2.1.3.Ур чадварын шалгалт авах бол шалгалтын агуулга, хэлбэр, бүтэц, хугацаа, байршил, дүгнэх аргачлал;

3.2.1.4.Оюутныг хөнгөлөлттэй нөхцөлөөр элсүүлэх болзол, шаардлага, бүрдүүлэх материал;

3.2.1.5.Бүрэлдэхүүний болон харьяаллын ерөнхий боловсролын сургуулийн ахлах сургуулийг тухайн онд төгсөгчдөөс элсүүлэх болзол, шаардлага, бүрдүүлэх материал;

3.2.1.6. дээд боловсрол эзэмшсэн хүнийг элсүүлэх болон мэргэжлийн шаталсан сургалтаар дэвшүүлэн суралцах болзол, шаардлага, бүрдүүлэх материал;

3.2.1.7.Гадаад оюутан элсүүлэх болзол, шаардлага, бүрдүүлэх материал;

3.2.1.8.Элсэлт болон ур чадварын шалгалт зохион байгуулах комисс, түүний эрх, үүрэг

3.2.1.9.Оюутан элсүүлэхтэй холбогдсон маргаан, гомдол шийдвэрлэлт;

3.2.2.Оюутан элсүүлэх үйл ажиллагааг сургууль бие даан зохион байгуулна.

3.2.2.1.Энэхүү журмын 2-т заасан шаардлага, болзлыг хангасан бүртгүүлэгчийн хүсэлтийг хүлээн авч, элсүүлнэ.

3.2.2.2.Бүртгүүлэгчийн оноо тэнцсэн тохиолдолд бүрэн дунд боловсролын гэрчилгээ дэх дүн, авьяас чадвартайг илэрхийлэх нотлох баримтууд, эсээ, ярилцлага зэрэг нэмэлт шалгуур тавьж болно.

3.2.2.3.Энэхүү журмын 2.4.6-д заасан бүртгүүлэгчийн ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгал төлсөн лавлагаа, өргөдөл болон эсээ /суралцах бэлтгэл хангасан байдал, авьяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлэх гэх мэт агуулгыг тусгасан байна./ зэргийг үндэслэн элсүүлнэ.

3.2.3.Ур чадварын шалгалт авах мэргэжил /хөтөлбөр/-ийн жагсаалтад багтсан сургалтын хөтөлбөрүүдээр ур чадварын шалгалтыг сургууль зохион байгуулна.

3.2.4.Ур чадварын шалгалтыг элсэн суралцах хөтөлбөрийн онцлогтой уялдуулан бичгийн ажил, тест, ярилцлага, кейс ажиллуулах, натюрморт зурах, сэдэвт зохиомж зурах, дуулах, бүжиглэх, хөгжимдөх, жүжиглэх, эсээ бичих, видео танилцуулга, сонсгол, хэмнэл шалгах, сэтгэц, зан үйлийн байдал, бие бялдрын бэлтгэгдсэн байдал, асуумж зэрэг хэлбэрээр авч, шалгуулагчийн ур чадварыг үнэлнэ.

3.2.5.Ур чадварын шалгалтын удирдамжийг тухайн сургуулийн элсэлтийн журамд оруулан баталгаажуулсан байна.

3.2.6.Ур чадварын шалгалтын удирдамжид дараах зүйлсийг заавал оруулсан байна. Үүнд:

- Шалгуулагчийн бэлдэж ирэх зүйлс
- Гүйцэтгэх даалгаврын төрөл, хэлбэр
- Үнэлгээний шалгуур, үзүүлэлт
- Шалгалтыг зохион байгуулалт, байршил, хугацаа.

3.2.7.Сургууль шалгуулагч бүрийн ур чадварын анхны оноо буюу гүйцэтгэлийн хувийг хөтөлбөр бүрээр 100 онооноос тооцоолж гаргана.

3.2.8.Ур чадварын шалгалтын гүйцэтгэлийн хувь буюу анхны онооноос хэмжээст оноо (хэмжээст оноо нь 200-аас 800-ийн хооронд байна)-г хөтөлбөр бүрээр энэхүү журмын 3.2.9-д заасан аргачлалаар тооцно. Анхны онооны интервалд харгалзах хэмжээст оноог хүснэгтээр харуулав.

	Анхны оноо (A)	Хэмжээс оноо (X)
1	0-59	200-479
2	60-64.9	480-519
3	65-69.9	520-559
4	70-74.9	560-599
5	75-79.9	560-639
6	80-84.9	640-679
7	85-89.9	680-719
8	90-94.9	720-759
9	95-100	760-800

3.2.9. Анхны оноог А, хэмжээст оноог Х гэж тэмдэглээд дараах байдлаар хэмжээст оноо (Х)-г тооцоолно. Үүнд:

- Хэрэв шалгуулагчийн анхны оноо 0-ээс 59-ийн хооронд бол $X=200+A*4.66$
- Хэрэв шалгуулагчийн анхны оноо 60-аас 100-ын хооронд бол $X=480+(A-60)*8$ гэсэн томъёогоор олно.

3.2.10. Ур чадварын шалгалтад 60 (хэмжээст оноогоор 480) болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

3.2.11. Шалгуулагчийн ур чадварын шалгалтын оноо тухайн шалгалтыг өгсөн сургууль, хөтөлбөрийн хувьд хүчинтэй байна.

3.2.12. Зарим хөтөлбөрөөр элсэлт авах онооны босгыг элсэлтийн шалгалтын үндэсний хэмжээний босго онооноос дээш байхаар тогтоож болно.

3.2.13. Оюутан элсүүлэх мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/-ийн индекс, суралцах хугацаа, хэлбэр, нийт судлах багц цаг, хяналтын тоо, элсэлтийн шалгалтын хичээлийн босго оноо, сургуулийн шалгуур шаардлага, ур чадварын шалгалтын босго оноо зэрэг мэдээллийг сургуулийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээлсэн байна.

3.2.14. Сургууль сургалтын хэлбэр, хичээлийн жилийн бүтэцтэй уялдуулан аймаг, нийслэлээс оюутан элсүүлэх ажлыг цахимаар болон тухайн байршил дээр элсэлтийн шалгалт дууссан өдрөөс хойш зохион байгуулна.

3.2.15. Сургууль тухайн мэргэжил /хөтөлбөр/-ээр суралцахад тавигдах элсэлтийн шалгалтын онооны шаардлага хангасан, Удирдах зөвлөлөөс баталсан хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг элсүүлнэ.

3.2.16. Өвлийн буюу 2 дахь удаагийн элсэлтийг энэхүү журмын 4.2-т баталсан элсэлтийн хяналтын тоог хөтөлбөр бүрээр гүйцээх байдлаар зохион байгуулна. Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр өвлийн элсэлт зохион байгуулах бол хаврын элсэлтийн тоотой нэгтгэсэн байдлаар баталсан аргачлалын дагуу тооцож нэмэлт хяналтын тоог тогтооно.

3.3. Сургуульд гадаадын иргэдийг сургахад дараах арга хэмжээг авна. Үүнд:

3.3.1.Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцах хүсэлт гаргасан гадаадын иргэдээс авсан монгол хэлний мэдлэг, чадварын шалгалт, эсвэл англи хэлний олон улсын шалгалтын оноог харгалзан элсүүлэн суралцуулна. Тухайн сургууль элсэлтийн журамдаа гадаадын иргэнд тавих хэлний шаардлагыг тодорхой тусгана.

3.3.2.Энэ журмын 3.3.1-д заасан шалгалтын даалгавар “Монгол хэлний тухай” хуулийн 22 дугаар зүйлд заасан байгууллагаас боловсруулсан гадаадын иргэнээс авах монгол хэлний түвшин тогтоох шалгалтын агуулгын хүрээнд боловсруулсан байна.

3.3.3.Монгол хэлний түвшин тогтоох шалгалтын шаардлага хангаагүй гадаадын иргэнийг монгол хэлний бэлтгэл ангид бүртгэн суралцуулна.

3.3.4.Тухайн улсын элсэлтийн шалгалттай дүйцэх шалгалтын оноог Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагаар дүйцүүлэн тооцуулж батламж авсан байна.

3.3.5.Гадаадын иргэн харьяатын газарт хандан тухайн гадаад оюутны Монгол Улсад оршин суух үнэмлэх авах хүсэлт гаргахдаа монгол хэлний шалгалтын дүнг хавсаргасан байна.

3.3.6.Гадаад хэлээр сургалт явуулдаг хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд тухайн гадаад хэлний шаардлага хангасан гадаадын иргэнийг элсүүлнэ.

3.4.Сургууль элсэлтийн комисс болон ур чадварын шалгалтын комиссыг захирлын тушаалаар байгуулна. Элсэлтийн комисс оюутан элсүүлэхтэй холбоотой аливаа маргаан, бүртгүүлэгч болон тэдний хууль ёсны төлөөлөгчийн гаргасан санал, гомдлыг холбогдох журмын дагуу шуурхай шийдвэрлэх, элсэлтийн явцад хяналт тавих, элсэлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулна.

Дөрөв.Элсэлтийн хяналтын тоо тогтоох

- 4.1.Сургууль бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт оюутан элсүүлэх хяналтын тоо тогтоохдоо тус тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлал”-ыг (цаашид “Аргачлал” гэнэ) баримтална.
- 4.2.Сургуулийн удирдах зөвлөлөөс хөтөлбөр бүрээр оюутан элсүүлэх хяналтын тоог аргачлалын дагуу тогтоож жил бүрийн 5 дугаар сард багтаан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 4.3.Сургуулиас ирүүлсэн оюутан элсүүлэх хяналтын тоог аргачлалын дагуу тогтоосон эсэхийг хянаж дээд боловсролын удирдлага мэдээллийн системд оруулна.
- 4.4.Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд төрийн өмчийн их сургуулийн орон нутгийн салбар, харьяа сургуульд зарим хөтөлбөрийн хяналтын тоог зөвхөн тухайн орон нутагт тогтоон элсүүлж, хамтарсан хөтөлбөр байдлаар зохион байгуулж болно.
- 4.5.Цэрэг, цагдаа (аюулгүй байдлын чиглэл)-гийн сургуульд элсэгчийн хяналтын тоог захиалагч байгууллагын саналыг харгалзан тухайн сургууль тогтооно.

Тав. Бусад

- 5.1.Ахисан түвшний хөтөлбөрт элсэгчийн өмнөх боловсролын зэрэг цахим системд баталгаажуулсан байна. Элсэгчид тавигдах бусад шаардлагыг холбогдох журмаар зохицуулна.
- 5.2.Удирдах зөвлөлөөс баталсан оюутан элсүүлэх хяналтын тоог хэтрүүлэхийг хориглоно.
- 5.3.Сургууль сургалт эрхлэх зөвшөөрөл аваагүй мэргэжил /хөтөлбөр/-ээр элсэлт авсан, элсүүлэх мэргэжил /хөтөлбөр/-ийн нэрийг өөрчлөн зарласан, эсхүл тухайн мэргэжил /хөтөлбөр/-ийн элсэлтийн шалгалтын хичээл, босго онооны шаардлага хангаагүй элсэгчийг элсүүлсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.
- 5.4.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа сургуулийн элсэлтийн шалгалтын босго онооны болзол ханган элссэн суралцагч эхний 2 хичээлийн жилд 2.8 ба түүнээс дээш голч дүнтэй суралцсан тохиолдолд тухайн мэргэжил /хөтөлбөр/-ээр нийслэлд байршилтай сургуульд шилжин суралцаж болно.

Тайлбар: Энэ журмын 5.4 дахь заалт сургуулийн хамтарсан хөтөлбөрийн хүрээнд хийгдэх шилжилт хөдөлгөөнд хамаарахгүй болно.

-----oO-----

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2024 оны 03 дугаар сарын 20-ны
өдрийн А.1.143 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ЭЛСЭЛТИЙН ХЯНАЛТЫН ТООГ ТОГТООХ АРГАЧЛАЛ

Дээд боловсролын сургалтын байгууллага бакалаврын сургалтын хөтөлбөрт оюутан элсүүлэх хяналтын тоог тухайлсан хөтөлбөр бүрээр тодорхойлно. Элсэлтийн хяналтын тоог дараах алхмаар тодорхойлно. Үүнд:

- Багшийн ачаалал: Багшийн ачаалал, тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үүсэх сургалтын үйл ажиллагааны ачааллыг тооцоолж, элсэлтийн боломжит бүлгийн тоог хөтөлбөр бүрээр тодорхойлох;
- Орчин нөхцөл: Хөтөлбөр бүрээр тодорхойлсон нийт бүлэгт сургалтын анги танхим болон лаборатори хүрэлцээтэй эсэхийг тооцох;
- Хичээллэх боломжтой бүлгийн тоонд үндэслэн элсэлтийн хяналтын тоог тодорхойлно.

1. Багшийн ачааллыг тооцох

Тухайн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй үүсэх сургалтын үйл ажиллагааны ачаалал болон хөтөлбөрийн үндсэн багшийн нормыг тооцсоны үндсэн дээр элсэлтийн хяналтын тооны эхний саналыг тодорхойлно.

1.1. Багшийн ачаалал (FC-faculty capacity): Үндсэн болон зөвлөх, гэрээт багшийн тухайн хичээлийн жилд гүйцэтгэх сургалтын А цагийг нормоор тодорхойлно. Үндсэн багшийн хувьд хичээлийн жилийн сургалтын А цагийн ачааллыг 15 багц цаг, зөвлөх, гэрээт багшийн сургалтын А цагийн ачааллыг 6 багц цаг гэж нийтлэгээр авч үзнэ.

1.1.1 Сургуулийн нийт үндсэн багшийг мэргэжлийн хичээлийн хөтөлбөр хэрэгжүүлж буй байдлаас хамааруулан аль нэг сургалтын хөтөлбөрт (хөтөлбөрийн багш) харьяалуулна. Нэг хөтөлбөрт харьяалуулан тооцсон багшийг өөр хөтөлбөрт давхардуулан тооцохгүй. Төрөлжсөн нэг чиглэлийн ижил суурьтай сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг багшийг тодорхой нэг хөтөлбөрт харьяалуулах боломжгүй тохиолдолд хөтөлбөрийн төрөлжсөн чиглэлээр багцлан авч үзэж болно. Биеийн тамир, гадаад хэл зэрэг зөвхөн ерөнхий суурийн хичээл ордог үндсэн багшийг мэргэжлийн хөтөлбөрт харьяалуулахгүй.

1.1.2 Хөтөлбөрийн багш тус бүрийн сургалтын А цагийн нормыг нэмж нийт хөтөлбөрийн багшийн сургалтын ачааллыг тодорхойлно.

$$FC = FC^P + FC^G$$

$$FC^P = g \cdot \beta \cdot (15 \cdot N_i^F + 6 \cdot N_i^C) \text{ ба } FC^G = 15 \cdot N^G / P$$

Энд: N_i^F нь нийт үндсэн багшийн тоо, N_i^C нь гэрээт багшийн тоо, N_i^G нь хөтөлбөрт

харьяалуулаагүй үндсэн багшийн тоо. P нь идэвхтэй хэрэгжүүлж буй бакалаерын нийт хөтөлбөрийн тоо. β нь үндсэн багш цагийн нормоо давуулан гүйцэтгэх эсэхтэй холбоотой коэффициент ба $1 \leq \beta \leq 1.4$ байна. g нь тухайн мэргэжлийн чиглэлийн дагуу идэвхтэй хэрэгжиж буй ахисан түвшний хөтөлбөрийн тооноос хамаарна. Тухайн мэргэжлийн чиглэлийн дагуу магистрын p_m тооны, докторын p_d тооны хөтөлбөр хэрэгжүүлдэг бол $g = 1 - p_m \cdot 0.1 - p_d \cdot 0.1$ томъёогоор тодорхойлогдоно. FC^G нь биеийн тамир, гадаад хэл зэрэг зөвхөн ерөнхий суурийн хичээл ордог, хөтөлбөрт хамааруулах боломжгүй үндсэн багшийн нормыг нийт хэрэгжүүлж буй хөтөлбөрт хуваасан нэмэгдэх норм.

1.2. Хөтөлбөрийн ачаалал (PR-program requirement): Тухайн мэргэжлийн хөтөлбөрийн оюутанд санал болгож буй төлөвлөгөөгөөр 1-4 дүгээр түвшин (дамжаа) бүрд жигд 30 багц цагийн хичээлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг, нэг бүлэгт 30 хүртэл суралцагчтай гэж үзнэ.

1.2.1. Тухайн мэргэжлийн хөтөлбөрийн оюутанд санал болгож буй төлөвлөгөөний 3 болон 4 дүгээр түвшинд мэргэжлийн хичээлүүд байх тул өөр хөтөлбөртэй хамтатган судлах боломжгүй буюу дангаараа судлах хичээлүүдээс тогтоно гэж үзнэ. 3 дугаар түвшний нийт 30 багц цагийн хичээлийг 1 бүлэгт заахад 30 багц цагийн ачаалал шаардлагатай (3 багц цагийн хичээлийн 2 багц цаг 7 хоногт 2 хичээлийн цагаар нэг удаагийн лекц, 1 багц цаг 7 хоногт 2 хичээлийн цагаар нэг удаагийн семинар/лабораторийн ажил гэж үзэх ба 30 багц цаг гэдгийг 3 багц цагийн 10 хичээл гэж үзнэ). 3 ба 4 дүгээр түвшин тус тусдаа нэг нэг бүлэгтэй тохиолдолд нийт 60 багц цагийн багшийн ачаалал шаардана.

Тухайн мэргэжлийн хөтөлбөрийн оюутанд санал болгож буй төлөвлөгөөний 3 ба 4 дүгээр түвшин нэгээс олон (k_3, k_4) бүлэгтэй тохиолдолд лекцийг бүлэг дунд 2 багц цагаар хамтатган, семинар/лаборатори бүлэг тус бүрд 1 багц цагаар дангаар орохоор тооцох тул олон бүлэг бүхий түвшний багшийн нийт ачаалал 3 багц цаг бүхий 1 хичээлийн хувьд $(2 + k)$ хэлбэрээр; дэлгэрүүлбэл k_3 бүлэг бүхий 3-р түвшний ачаалал $\frac{30}{3} * (2 + k_3)$, k_4 бүлэг бүхий 4-р түвшний ачаалал $\frac{30}{3} * (2 + k_4)$ гэж тодорхойлогдоно.

1.2.2. Оюутанд санал болгож буй төлөвлөгөөний 1 ба 2 дугаар түвшинд судлах хичээлүүд ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлүүдээс голчлон бүрдэж лекцийн хичээлийг өөр хөтөлбөрийн суралцагчидтай хамтатган судлуулах боломжтой гэж үзнэ. Тухайлбал 1-р түвшинд судлах 3 багц цагийн нэг хичээл 2 өөр хөтөлбөрт заахад хөтөлбөр тус бүрд 3 багц цагийн хичээлийг тодорхойлох боловч багшаас 7 хоногт дундын 2 хичээлийн цагийн лекц (нийт 2 багц цаг) 2 хөтөлбөрийн бүлэг тус бүрд 2, 2 хичээлийн цагийн (тус бүр 1 багц цаг) семинар/лабораторийн ажил буюу нийт 4 багц цагийн ачаалал шаардана. Өөрөөр хэлбэл 2 өөр хөтөлбөр тус бүрдээ 3, 3 буюу нийт 6 багц цагийн ижил хичээлийг хамтатган заахад 4 багц цагийн багшийн ачаалал шаардана. Иймд тухайлсан нэг хөтөлбөрийн багшийн ачааллыг 3 багц цагийн хичээлд 2 багц цагийн ачаалал авна гэж үзнэ. 1 ба 2-р түвшний багшийн авах нийт ачаалал нь тус бүр 1, 1 бүлэгтэй тохиолдолд $60/3 * 2 = 40$ багц цаг байна.

Хөтөлбөрийн 1 ба 2 дугаар түвшний бүлгийн тоог k_1, k_2 гэж үзвэл k_1 бүлэг

бүхий 1-р түвшний ачаалал $\frac{30}{3} * (1 + k_1)$, k_2 бүлэг бүхий 2-р түвшний ачаалал $\frac{30}{3} * (1 + k_2)$ гэж тодорхойлогдоно.

1.2.3. 1.2.1 болон 1.2.2 дугаар хэсгийн тооцооллоос үзэхэд оюутанд санал болгох төлөвлөгөөний 1-4 дүгээр түвшин бүрд 1 бүлэг бүхий хөтөлбөрийн 1 хичээлийн жилийн бүрэн ачаалал нь $60 + 40 = 100$ багц цаг байна. Түвшин бүрд суралцах суралцагчдын бүлгийн тоог k_1, k_2, k_3, k_4 гэж үзвэл хөтөлбөрийн бүрэн ачааллыг тодорхойлох томъёо:

$$PR = \frac{30}{3} * (1 + k_1) + \frac{30}{3} * (1 + k_2) + \frac{30}{3} * (2 + k_3) + \frac{30}{3} * (2 + k_4)$$

буюу

$$PR = 10 \times (6 + k_1 + k_2 + k_3 + k_4)$$

Энд: k_1 нь 1-р түвшинд элсүүлэх бүлгийн тоо, k_2, k_3, k_4 нь 2,3,4 дүгээр түвшинд дэвшин суралцах суралцагчийн бүлгийн тоо (мэдэгдэж буй).

5 дугаар түвшин (дамжаа)-тэй тохиолдолд k_5 -г нэмэх, дэд бакалаврын хөтөлбөрийн хувьд k_4 -г хасаж тооцохыг анхаарна уу.

1.3. Багшийн ачааллаас хамаарсан элсэлтийн хяналтын бүлгийн тоог тодорхойлох:

1.3.1. Тухайн хөтөлбөрийн хувьд $FC < PR$ буюу багшийн ачаалал тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үүсэх сургалтын үйл ажиллагааны ачааллыг үл хангахуйц тохиолдолд тухайн хөтөлбөрөөр элсэлт авах боломжгүй ($k_1 = 0$) гэж үзэж элсэлтийн хяналтын тоо тогтоохгүй.

1.3.2. Хэрэв $FC \geq PR$ тохиолдолд тухайн хөтөлбөрөөр элсэлт авах боломжтой. Элсүүлэх суралцагчийн бүлгийн хамгийн их тоог дараах харьцаагаар тодорхойлно.

$$k_1 = \left[\frac{FC}{10} \right] - 6 - k_2 - k_3 - k_4$$

Энд : $[\cdot]$ -нь бүхэл хэсгийг илэрхийлнэ.

2. Орчны нөхцөлийн хүрэлцээт байдлыг тооцох

Орчны хүрэлцээг сургуулийн хэмжээнд нэг удаа тооцоолно.

2.1. Тухайн сургуульд хэрэгжүүлж буй нийт хөтөлбөрт тусгагдсан хичээлийг хэрэгжүүлэх сургалтын анги танхим, лабораторийн өрөөний цагийн нэгтгэлийг хөтөлбөр, түвшин бүрээр суралцагчдын бүлгийн тоонд үндэслэн 7 хоногоор тодорхойлно. Хөтөлбөрийн 1 долоо хоногт хичээллэх сургалтын цагийн хэрэгцээ (ER-environmental requirement):

$$ER = \alpha_b \cdot ER_b + \alpha_m \cdot ER_m + \alpha_d \cdot ER_d$$

$$ER_b = 5 \times \sum_{i=1}^{n_b} (6 + k_1^i + k_2^i + k_3^i + k_4^i)$$

$$ER_m = 5 \times \sum_{i=1}^{n_m} (4 + k_1^i + k_2^i)$$

$$ER_d = 5 \times \sum_{i=1}^{n_d} (6 + k_1^i + k_2^i + k_3^i)$$

Энд: ER_b, ER_m, ER_d – нь харгалзан бакалавр, магистр, докторын хөтөлбөрүүдийн сургалтын цагийн хэрэгцээ, n_b, n_m, n_d – нь харгалзан тухайн сургуулийн хэрэгжүүлж буй бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн тоо, k_j^i – нь i дүгээр хөтөлбөрийн j дүгээр түвшин дэх бүлгийн тоо. $\alpha_b, \alpha_m, \alpha_d$ – нь харгалзан бакалавр, магистр, докторын түвшний хөтөлбөрийн нийт хичээлийн хэдэн хувь нь бүрэн цахим хэлбэрт шилжсэнийг илэрхийлэх коэффициент.

2.2. Сургуулийн хэмжээнд буй сургалтын анги танхим, лабораторийн өрөөний боломжит хуваарийн нөөцийг (EC-environmental capacity) 7 хоногоор тодорхойлно.

$$EC = m \times 10 \times 5$$

Энд: EC - нь сургуулийн нийт анги танхим, лабораторийн нөөц (7 хоногоор), m – нийт анги, танхимын тоо (1 ангид өдөрт хичээллэх цагийг 10, 7 хоногийн ажлын хоногийг 5 гэж үзнэ).

Нарийн мэргэжлийн лаборатори шаардах хичээлийн хувьд тухайн хичээл тус бүрээр лабораторийн хэрэгцээ болон нөөцийг нарийвчлан авч үзнэ.

2.3. Сургуулийн сургалтын анги танхим, лабораторийн өрөөний боломжит хуваарийн нөөц нь хөтөлбөрийн шаардах ачаалалд хүрэхгүй буюу $EC < ER$ тохиолдолд хөтөлбөрөөр элсүүлэх оюутны бүлгийн тоо(k_1) –г нэгээр цөөрүүлж дахин тооцоолно. $EC \geq ER$ тохиолдолд I алхмаар тодорхойлсон элсэлтийн хяналтын тооны бүлгийн тоонууд нь орчны хүрэлцээнд нийцнэ гэж үзнэ.

3. Энэхүү аргачлалын I болон II алхмаар тодорхойлогдсон боломжит бүлгийн тоо k_1 -г 1 бүлэгт 30 суралцагч гэж тооцоход $30 \times k_1$ нь тухайн хөтөлбөрөөр элсүүлэх боломжит нийт суралцагчийн тоо болно.

I. Хөтөлбөрийн хяналтын бүлгийн тоог багшийн ачааллаас хамааруулан тооцох жишээ

Сургууль нийт 8 бакалаврын хөтөлбөр хэрэгжүүлдэг ба тухайн А хөтөлбөрт мэргэжлийн хичээл заадаг үндсэн орон тооны 1 профессор, 2 дэд профессор, 1 ахлах багш, 2 багштай, мөн 1 зөвлөх болон 1 гэрээт багштай гэж үзье. Уг сургуульд зөвхөн ерөнхий суурийн хичээл заадаг, аль нэг хөтөлбөрт хамааруулаагүй 10 үндсэн багштай гэвэл уг багш нарын нийт стандарт ачаалал 150 кредит болно. Мөн тухай хөтөлбөрийн чиглэлээр магистрын болон докторын тус бүр 1 хөтөлбөр хэрэгжүүлдэг гэж үзье. Тухайн хөтөлбөрөөр ирэх хичээлийн жилд 2, 3, 4-р түвшинд дэвшин суралцах суралцагчдын тоо харгалзан 28, 18, 38 гэж үзвэл $k_2 = 1, k_3 = 1, k_4 = 2$ болно.

А хөтөлбөрийн цагийн багтаамж болон ачааллын талаарх мэдээлэл болон хэдэн бүлэг оюутанд үйлчлэх боломжтойг тооцоолсныг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт. Хөтөлбөрийн хяналтын бүлгийн тоо тооцсон жишээ

Хөтөлбөрийн нэр		А
Хөтөлбөр хариуцсан багш нарын тоо /албан тушаалын ангиллаар/		Профессор-1, дэд профессор-2, ахлах багш-1, багш-2, зөвлөх багш-1, гэрээт багш-1
Үзүүлэлт	Тооцоолсон үр дүн	Тайлбар
β	1.2	Үндсэн багш нар нормоо 20% давуулан биелүүлэхээр тооцоход
g	0.8	Тухайн мэргэжлийн чиглэлээр магистрын-1, докторын 1 хөтөлбөр хэрэгжүүлдэг
FC^P	97.92	$1.2 \cdot 0.8 \cdot (6 \cdot 15 + 2 \cdot 6)$
FC^G	18.75	$10 \cdot 15 / 8$
FC	116.67	$97.92 + 18.75$
PR	$100 + 10k_1$	$PR = 10 \cdot (6 + k_1 + 1 + 1 + 2)$
1-р түвшинд элсүүлэх бүлгийн тоо k_1	2	$FC > PR$ тул $k_1 = [116.67 / 10] - 6 - 1 - 1 - 2 = 2$
Багшийн ачааллаас хамааран элсүүлэх оюутны тоо	60	$k_1 \cdot 30 = 2 \cdot 30$

-----oOo-----

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 20 – ны өдрийн А/143 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨГСӨЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1. Энэ журмаар дээд боловсролын сургалтын байгууллага /цаашид “сургууль” гэх/ -ын төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, төгсөгчдөд дээд боловсролын зэргийн диплом /цаашид “диплом” гэх/ олгох, бүртгэх, баталгаажуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Дээд боловсролын төгсөгчдөд дэд бакалаврын, бакалаврын, магистрын болон докторын хөтөлбөрийн агуулга эзэмшсэнийг гэрчилсэн диплом олгоно. Диплом нь дээд боловсролын тухайн түвшний шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг мөн.
- 1.3. Дипломын загварыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 1.4. Иргэнд дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж төгссөн талаарх лавлагаа, тодорхойлолтыг Дээд боловсролын удирдлага мэдээллийн системийн мэдээлэл болон архивын баримтад үндэслэн Боловсролын ерөнхий газар олгоно.

Хоёр. Төгсөлтийн үйл ажиллагаа

- 2.1. Энэхүү журамд нийцүүлэн сургууль төгсөлтийн үйл ажиллагааг зохицуулах журам батлан мөрдөнө.
- 2.2. Төгсөгч Дээд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасан боловсролын тухайн түвшний шаардлагад нийцүүлэн баталсан сургалтын төлөвлөгөөний багц цагийг бүрэн дүүргэсэн байна.
- 2.3. Тухайн сургалтын хөтөлбөрт тусгагдсан агуулгыг эзэмшиж, үнэлгээний зохих шаардлагыг хангасан, дэд бакалаврын зэрэгт 2.5 жил, бакалаврын зэрэгт 3.0 жил, магистрын зэрэгт 1 жил, докторын зэрэгт 2.5 жилээс доошгүй хугацаанд Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд байршсан суралцагчид төгсөх эрх үүснэ.
- 2.4. Журмын 2.3-д заасан суралцагч тодорхой кредитийг дүйцүүлэн тооцуулсан тохиолдолд Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд байршсан байх шаардлагын хугацаа богиносж болно. Энэ тохиолдолд кредитийг дүйцүүлэн тооцуулсан талаарх мэдээллийг сургууль албан бичгээр Боловсролын ерөнхий газарт гаргана.
- 2.5. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалтын дагуу эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдсан байна.
- 2.6. Төгсөлтийг тухайн хичээлийн жилийн зургаа болон нэгдүгээр сард багтааж хоёр удаа хийж болно.

- 2.7.Сургууль төгсөлтийн болон төгсөгчийн дүн тулгалтын комиссыг захирлын тушаалаар байгуулна.
- 2.8.Дүн тулгалтын комиссын тайлан, төгсөгчийн дүнгийн хавтгайг баталгаажуулан сургуулийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж, мэргэжилтэн хянан баталгаажуулна.
- 2.9.Төгсөлтийн үйл ажиллагааны тайланг тухайн сургуулийн захирлын зөвлөлөөр хэлэлцэж холбогдох дүгнэлт гаргасан байна.
- 2.10.Ахисан түвшний төгсөлтийн үйл ажиллагааг энэ журмын 2.1-д заасан журмаар зохицуулна.
- 2.11.Хамгаалалтаас өмнө дипломын ажлын хуулбарлалтын хувийг тогтоож, холбогдох нэгжийн дүгнэлтийг хавсаргасан байна.
- 2.12.Төгсөгчийн бакалаврын дипломын ажлыг сургуулийн номын санд цахим хэлбэрээр, магистрын төгсөлтийн ажлыг сургуулийн номын санд цаасан болон цахим хэлбэрээр хадгална.
- 2.13.Докторын зэрэг хамгаалуулах үйл ажиллагааг холбогдох дүрмээр зохицуулна.
- 2.14.Төгсөлтийн комисс төгсөлттэй холбоотой аливаа маргаан, санал, гомдлыг холбогдох журмын дагуу шуурхай шийдвэрлэх, төгсөлтийн явцад хяналт тавих үйл ажиллагааг зохицуулна.

Гурав. Дээд боловсролын дипломд тавих шаардлага

- 3.1.Диплом Дээд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д заасны дагуу шатлалтай байна.
- 3.2.Диплом улсын дугаар, цахим код, сургуулийн бүртгэлийн дугаартай байна.
- 3.3.Дипломын улсын дугаарын эхний тоо дээд боловсролын зэргийг илтгэх дугаар байх бөгөөд дараах 4 орон төгссөн оныг, сүүлийн 5 орон тухайн жилийн төгсөгчдийн дугаарыг тус тус илэрхийлнэ. Дэд бакалаврын зэргийн дугаар 5, бакалаврын зэргийн дугаар 6, магистрын зэргийн дугаар 7, докторын зэргийн дугаар 8 болно.
- 3.4.Боловсролын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д зааснаар дипломын үндсэн мэдээллийг агуулсан дахин давтагдашгүй цахим кодыг дипломд байршуулна.
- 3.5.Сургуулийн бүртгэлийн дугаар тухайн сургуулиас тухайн жилд олгосон дипломын бүртгэлийн дугаарыг илэрхийлэх бөгөөд давхардалгүй байна.
- 3.6.Дипломын нүүр хэсэг дараах агуулгатай байна (Тушаалын гуравдугаар хавсралт). Үүнд:
 - 3.6.1.Сургуулийн нэр, лого
 - 3.6.2.Дипломын улсын дугаар, цахим код
 - 3.6.3.Төгсөгчийн харьяалал /улс/, овог, нэр
 - 3.6.4.Хөтөлбөрийн нэр, индекс
 - 3.6.5.Боловсролын зэрэг /дэд бакалавр, бакалавр, магистр, доктор/
 - 3.6.6.Захирлын тушаалын огноо, дугаар
 - 3.6.7.Гарын үсэг /тушаал гаргасан захирлын гарын үсэг/
 - 3.6.8.Тамга
- 3.7.Дээд боловсролын дэд бакалавр, бакалаврын дипломын хавсралт хэсэг дараах агуулгатай байна. Үүнд:

- 3.7.1.Сургуулийн нэр /харьяа, салбар, бүрэлдэхүүн сургуулийн нэр/
- 3.7.2.Дипломын улсын дугаар, цахим код
- 3.7.3.Төгсөгчийн овог нэр, регистрийн дугаар
- 3.7.4.Элссэн он, төгссөн он, төгсөлтийн тушаалын дугаар
- 3.7.5.Хөтөлбөрийн нэр, индекс
- 3.7.6. Хөтөлбөрийн төрөлжүүлэн судалсан чиглэлийн нэр
- 3.7.7.Элсэлтийн шалгалтын оноо /нэгдүгээр хичээл/
- 3.7.8.Өмнөх шатны боловсролын үнэлгээний дундаж оноо
- 3.7.9.Судалсан хичээл, түүний үнэлгээ, багц цаг, нийт цуглуулсан багц цаг, голч оноо, голч дүн
- 3.7.10.Дипломын ажлын нэр
- 3.7.11.Тухайн улирлын сургуулийн ижил мэргэжлийн төгсөгчдийн голч дүнгийн дундаж
- 3.7.12.Сургалт хариуцсан нэгжийн даргын гарын үсэг, тэмдэг
- 3.7.13.Хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн тухай тэмдэглээ, бичиглэл, огноо, тэмдэг
- 3.7.14.Диплом, хавсралтыг кирилл, англи, монгол бичиг гэсэн 3 хувилбараар гаргана.
- 3.7.15.Үнэлгээний системийн мэдээлэл

3.8.Дээд боловсролын магистр, докторын дипломын хавсралт хэсэг дараах агуулгатай байна. Үүнд:

- 3.8.1.Сургуулийн нэр /харьяа, салбар, бүрэлдэхүүн сургуулийн нэр/
- 3.8.2.Дипломын улсын дугаар, цахим код
- 3.8.3.Төгсөгчийн овог нэр, регистрийн дугаар
- 3.8.4. Элссэн он, төгссөн он, төгсөлтийн тушаалын дугаар
- 3.8.5.Хөтөлбөрийн нэр, индекс
- 3.8.6.Хөтөлбөрийн төрөлжүүлэн судалсан чиглэлийн нэр
- 3.8.7.Судалсан хичээл, түүний үнэлгээ, багц цаг, нийт цуглуулсан багц цаг, голч дүн, голч оноо
- 3.8.8.Эрдэм шинжилгээний ажлын сэдвийн нэр
- 3.8.9.Сургалт хариуцсан нэгжийн даргын гарын үсэг, тэмдэг
- 3.8.10.Хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн тухай тэмдэглээ, бичиглэл, огноо, тэмдэг
- 3.8.11.Диплом, хавсралтыг кирилл, англи, монгол бичиг гэсэн 3 хувилбараар гаргана.

3.9.Сургууль төгсөгчдөд дипломын нүүр, хавсралтаас гадна нэмэлт хавсралт өгч болно.

Дөрөв. Дипломын дугаар захиалах, олгох, хэвлэх, баталгаажуулах

4.1.Дипломын дугаарын захиалгыг дор дурдсан байдлаар хийнэ:

4.1.1.Сургууль дээд боловсролын сургалтын хөтөлбөрөө амжилттай судалсан, төгсөх шаардлагыг хангасан суралцагчдад төгсөлтийн тушаал, хамгаалуулах зөвлөлийн тогтоол гаргаж баталгаажуулсан байна.

4.1.2.Сургууль төгсөгчдийн дипломын дугаарын захиалгыг Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд үүсгэж, элсэлт, төгсөлтийн тушаал эсвэл хамгаалуулах зөвлөлийн тогтоолыг албан бичгээр Боловсролын ерөнхий газарт хүргүүлнэ.

4.1.3.Сургуулиас ирүүлсэн материал болон дээд боловсролын удирдлага мэдээллийн системийн төгсөлтийн мэдээлэлд тулгалт хийж, дугаарыг Дээд боловсролын удирдлага мэдээллийн системээр олгоно.

4.2.Сургууль дипломыг цахим хэлбэрээр олгоно. Төгсөгчийн хүсэлтээр дипломыг үнэт цаасаар хэвлэн олгож болно.

4.3.Сургууль дипломыг үнэт цаасаар олгохдоо албан ёсны эрхтэй хэвлэх үйлдвэрт хэвлүүлнэ.

4.2.Сургууль төгсөгчдийн дипломыг блокчейнээр баталгаажуулна. Блокчейнээр баталгаажуулах эрх бүхий мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулан, хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

4.3.Энэхүү журмын 1.3-т заасан загварын дагуу төгсөгчдийн дипломыг сургууль блокчейнд байршуулж баталгаажуулах хүсэлтийг Боловсролын ерөнхий газарт илгээнэ.

4.4.Боловсролын ерөнхий газар хүлээгдэж буй дипломыг шалгаж, блокчейнд баталгаажуулна.

4.5.Төгсөгчид олгох диплом олгосон тушаал, тушаалын хавсралт, төгсөгчдийн тайланг батлагдсан статистикийн маягтын дагуу гаргаж Боловсролын ерөнхий газарт жил бүрийн 7 дугаар сарын 25, 2 дугаар сарын 25-ны өдрийн дотор сургууль хүргүүлнэ. Сургууль нь төгсөлтийн мэдээллийн үнэн зөвийг хариуцна.

4.6.Боловсролын ерөнхий газар диплом болон холбогдох бусад мэдээллийг блокчейн технологийг ашиглаж хадгалан, төгсөгчдийн лавлагааны санг бүрдүүлнэ.

4.7.Аюулгүй байдал судлалаар дагнан сургалт, судалгааны ажил эрхэлдэг төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад энэ журмын 4.5, 4.8, 9.2 дахь заалтууд хамаарахгүй бөгөөд чиг үүргийн онцлогт нийцүүлэн Боловсролын ерөнхий газар шийдвэрлэнэ.

4.8.Төгсөгчдийн лавлагааг дипломын дугаар ашиглан шалгаж боломжийг Боловсролын ерөнхий газарт бүрдүүлнэ.

4.9.Боловсролын ерөнхий газар диплом олгосон тайланг Архивын тухай хуульд заасны дагуу архивд шилжүүлнэ.

Тав. Диплом бүртгэх, хадгалах

5.1.Боловсролын ерөнхий газар мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлт хийхтэй холбоотой асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулна.

5.2.Нөхөн бүрдүүлэлт хийхэд дипломыг дор дурдсан баримт бичигт үндэслэн бүртгэнэ. Үүнд:

- Боловсролын зэрэг олгох тухай сургуулийн захирлын тушаал
- Сургалт хариуцсан нэгжээс шалгаж баталгаажуулсан багц цаг, хичээлийн нэр, дүн, голч дүн, голч оноо
- Диплом, түүний хуулбар
- Иргэний үнэмлэх

5.3.Төгсөгчдөд олгосон диплом түүний хавсралтын хуулбар болон диплом олгосон шийдвэр, бүртгэл, холбогдох тайлангийн хамт сургуулийн архивд 30 жил хадгална.

5.4.Татан буугдсан сургууль Дээд боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасны дагуу үйл ажиллагаа явуулах хугацаандаа гаргасан тушаал шийдвэр, нийт төгссөн оюутны диплом болон түүний хавсралт олгосон тайлан мэдээг цахим хэлбэрээр гаргаж, татан буугдах шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Үндэсний төв архив болон Боловсролын ерөнхий газарт тус тус хүлээлгэн өгнө.

Зургаа. Боловсролын баримт бичиг дахин олгох

6.1.Блокчейнд баталгаажсан дипломыг иргэн өөрийн эрхээр нэвтэрч хэвлэн ашиглана.

6.2.Блокчейнд баталгаажуулахаас өмнөх үеийн дипломыг иргэн үрэгдүүлсэн, гэмтээсэн, хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд сургууль дахин олгоно.

6.3.Иргэнд анх олгосон дипломын улсын дугаар дахин олгох дипломд хэвээр хадгалагдана.

6.4.Энэ журмын 6.2-д заасан шалтгааны улмаас диплом дахин авах иргэн дараах материал бүрдүүлж төгссөн сургуульдаа хандана:

6.4.1.Диплом дахин авах болсон шалтгааныг бичсэн хүсэлт;

6.4.2.Дипломын архивын лавлагаа;

6.4.3.Дипломын хуулбар;

6.4.4.Иргэний хувийн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд нотлох баримтын хуулбар;

6.4.5.Диплом хэвлэх дахин олгох зардал төлсөн баримт.

6.5.Сургууль энэ журмын 6.4-д заасан нотлох материалд үндэслэн иргэнд дипломыг дахин олгоно.

6.5.1.Төгсөгчдөд дахин олгох дипломыг хэвлэн баруун дээд хэсэгт “Дахин олгов” гэсэн тэмдэглэгээ хийж, эрх бүхий этгээд баталгаажуулан иргэнд хүлээлгэн өгнө.

6.5.2.Сургууль диплом дахин олгосон бүртгэлийг хөтлөн, иргэний бүрдүүлсэн материалын хамт сургуулийн архивд хадгална.

6.6.Иргэнд анх олгосон дипломын улсын дугаар тодорхойгүй тохиолдолд холбогдох баримт бичигт үндэслэн шинээр дугаар олгож болно.

6.7.Татан буугдсан сургуулийн дээд боловсролын дипломыг нөхөн олгох асуудлыг Боловсролын ерөнхий газар хариуцна.

Долоо. Гадаад улсын дээд боловсролын баримт бичгийг дүйцүүлэх, лавлагаа гаргах

7.1.Гадаад улсын их, дээд сургууль, коллежид суралцаж дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг авсан иргэнд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон дээд боловсролын баримт бичгийг Монгол Улсын дээд боловсролын зэрэгтэй дүйцүүлж болно.

7.2.Энэхүү журмын 7.1-д заасан баримт бичиг Монгол Улсын тухайн түвшний боловсролын баримт бичигтэй дүйцэх эсэх тодорхойлолт, тухайн гадаадын

сургуулийг төгссөн эсэх лавлагааг Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага гаргана.

7.3.Журмын 7.2-т заасан тодорхойлолт авах, дүйцүүлэх хүсэлт гаргахад дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

7.3.1.Боловсролын баримт бичиг дүйцүүлэх өргөдөл;

7.3.2.Гадаад улсад дээд боловсрол эзэмшсэнийг гэрчлэх боловсролын баримт бичгийн эх хувь, нотариатаар баталгаажуулсан хуулбар, түүний албан ёсны орчуулга /орчуулгын товчооны тамгатай байх/;

7.3.3.Монгол Улсын иргэн бол гадаад паспортын хувийн мэдээлэл бүхий хуудас, суралцах хугацаандаа Монгол Улсын хилээр гарсан, орсон тухай тэмдэглэлийн хуулбар.

Найм. Гадаад улсад суралцсан дээд боловсролын дипломыг бүртгэх, баталгаажуулах

8.1.Монгол улсын иргэн гадаад улсад дээд боловсролын зэрэг эзэмшихдээ Боловсролын ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д заасан цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.

8.2.Энэхүү журмын 8.1-д заасан санд бүртгэх үйл ажиллагааг Боловсролын ерөнхий газар хариуцна.

8.3.Гадаад улсад дээд боловсролын зэрэг эзэмшихээр суралцагч иргэн дараах мэдээллийг жил бүрийн 10 сард багтааж Боловсролын ерөнхий газарт цахимаар бүртгүүлнэ.

8.3.1.Суралцаж буй улс, сургууль, мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн нэр

8.3.2.Суралцаж буй дамжаа, төлбөрийн мэдээлэл /төрийн, хувийн тэтгэлэг/

8.3.3.Суралцах чиглэлээ сольсон тохиолдолд тухай бүрд мэдээллээ шинэчлэх.

8.4.Боловсролын зээлийн сангийн зээл, тэтгэлэг болон Засгийн газар хоорондын гэрээгээр гадаад улсад суралцагч энэ журмын 8.3-д зааснаас гадна гэрээнд тусгагдсан бусад мэдээллийг шаардлагатай хугацаанд шинэчлэн оруулна.

8.5.Гадаад улсад сурах иргэн өөрийн суралцах чиглэлээр элсэлтийн шалгалтын 2 хичээлийн босго онооны шаардлага хангасан эсхүл Гадаадын улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг хөтөлбөр, шалгалтын үнэлгээг Монгол Улсын элсэлтийн шалгалтын үнэлгээтэй дүйцүүлж батламж авсан байна.

8.6.Энэхүү журмын 8.5-д заасан шаардлага 30 дээш насны гадаадад суралцах иргэн болох ахисан түвшний суралцагчид хамаарахгүй.

8.7.Энэхүү журмын 8.3-д заасан мэдээллийг холбогдох хугацаанд оруулсан иргэнийг дипломын мэдээлэлд үндэслэн бүртгэнэ. Шаардлагыг биелүүлээгүй бол энэхүү журмын 7.2-д заасны дагуу лавлагаа авч мэдээллийн санд бүртгэнэ.

8.8.Гадаад улсын иргэн Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцах тохиолдолд сургууль энэхүү журмын 7.3-т заасан бичиг баримтыг хавсарган гадаад улсын дээд боловсролын дипломыг бүртгүүлэх хүсэлтийг Дээд боловсролын удирдлага мэдээллийн системээр дамжуулан цахимаар Боловсролын ерөнхий газарт гаргана.

- 8.9.Гадаад улсын иргэн бол гадаад улсын дээд боловсролын баримт бичиг бүртгүүлэх тухай өргөдөл бичиж, 7.3-т заасан бичиг баримтыг бүрдүүлэн Боловсролын ерөнхий газарт хандана.
- 8.10.Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагаас Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад ижил түвшинд шилжин суралцах иргэний хүсэлтийг шилжин суралцах сургууль судлан, шийдвэрлэнэ.
- 8.11.Дээд боловсролын баримт бичиг дүйцүүлэх, Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад үргэлжлүүлэн суралцах иргэний бүрдүүлсэн материал, гаргасан шийдвэрийг сургуулийн архивд хадгална.

Ес. Бусад

- 9.1.Энэхүү журмын хэрэгжилтэд Боловсролын ерөнхий газар, сургуулийн удирдлага, дотоод аудитын нэгж, эсхүл салбарын хяналтын газар хяналт тавина.
- 9.2.Сургууль нь төгсөгчдийн мэдээллийг үнэн зөв, бүрэн бүртгэж Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд оруулсан байна. Дээд боловсролын удирдлага мэдээллийн системд бүртгэлгүй, алдаатай бүртгэгдсэн, баталгаажуулаагүй иргэнд боловсролын зэрэг, диплом олгохгүй.
- 9.3.Дипломд бичигдэх мэдээлэлд өөрчлөлт оруулах, хууль бусаар баримт бичиг олгохыг хүсэх, шаардах, дарамтлах зэрэг хууль бус аливаа үйлдлийг хориглоно.
- 9.4.Энэхүү журмын 8.5-д заасан шаардлагыг 2025 оны зургаадугаар сараас хойш элсэгчээс эхлэн мөрдөнө.
- 9.5.Дипломыг хууль бусаар олгосон, хуурамчаар үйлдсэн, ашигласан, дээд боловсролын баримт бичгийг дахин олгоход энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээдийг хууль хяналтын байгууллагад иргэн, хуулийн этгээд мэдэгдэнэ.
- 9.6.Энэхүү журамд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2024 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн
#143 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

Дипломын нүүр

МОНГОЛ УЛС

[СУРГУУЛИЙН НЭР]

[БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГ]-ЫН ДИПЛОМ

Дугаар: 6-2024....

[Монгол улсын] иргэн овогтой нь

[ХӨТӨЛБӨРИЙН НЭР], [ИНДЕКС]

хөтөлбөрөөр суралцан төгссөн тул

захирлын [ТУШААЛЫН ОГНОО] өдрийн [ТУШААЛЫН ДУГААР] тоот тушаалаар

[САЛБАР УХААН]-ны [БОЛОВСРОЛЫН ЗЭРЭГ]-ын зэрэг олгов.

[СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН НЭР]

[СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ГАРЫН ҮСЭГ]

[Сургуулийн тамга]

ЛОГО

Магадлан
ИТГЭМЖИЛСЭН
байгууллагын
ЛОГО

[QR]

[СТИКЕР]

Магистр, докторын зэргийн дипломын хавсралт

[СУРГУУЛИЙН НЭР]

Магадлан
итгэмжилсэн
байгууллагын
лого

[ХАРЬЯА/САЛБАР/БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИЙН НЭР]

7-2023 ... дугаартай [боловсролын зэрэг]-ын дипломын хавсралт
Бүртгэлийн дугаар:

Лого

Эцэг /эх/-ийн нэр:

Нэр:

Регистрийн дугаар:

Хөтөлбөрийн нэр:

Төрөлжин чиглэл:

Өмнөх зэргийн дипломын дугаар:

Элссэн он:

Төгссөн он:

Тушаалын дугаар:

Хичээлийн нэр:	Багц цаг	Үсгэн үнэлгээ	Тоо үнэлгээ

Хичээлийн нэр:	Багц цаг	Үсгэн үнэлгээ	Тоо үнэлгээ

Хичээлийн нэр:	Багц цаг	Үсгэн үнэлгээ	Тоо үнэлгээ

Магистрын төгсөлтийн ажил/диссертацийн нэр:

Нийт багц цаг:

Голч оноо:

Голч дүн:

[Сургалт хариуцсан нэгжийн даргын нэр]

[Сургалт хариуцсан нэгжийн даргын гарын үсэг]

[Сургуулийн тамга]

[QR]

Дүн(голч): F<60(0) 60≤D<65(1.0) 65≤D<70(1.4) 70≤C<75(1.9) 75≤C <80(2.3) 80≤B<85(3.1) 85≤B<90(3.1) 90≤A<95(3.6) 95≤A<100(4.0) S=тооцов CR=дүйцүүлсэн багц цаг